



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Цахир сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2026/009/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Аудитор Л.Соёлмөнх
Утас: 7033-3019

Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.03.24 № 159

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Архангай аймгийн Цахир сумын Төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Архангай аймгийн Цахир сумын төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй 68,226.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй. Үүнд:

1. Сумын 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 274,777.5 мянган төгрөгөөр давсан боловч 5 нэр төрлийн орлогыг төлөвлөснөөс 6,049.1 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн;
2. Хоршоо хөгжүүлэх сангийн 4 зээлдэгчтэй холбоотой 20,349.0 мянган төгрөгийн чанаргүй хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй;

зэрэг нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11, 10 дугаар зүйлийн 10.1, 11 зүйлийн 11.3 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ЗДТГ, ИТХ, ОНХС, ХХС-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвийн тогтмол зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэгтгэсэн байна. Тус байгууллага нь орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2,631,122.7 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 2,032,735.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Цахир сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2025 онд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр 15 үндсэн зорилтын хүрээнд 112 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс **72.6** хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж олох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,030,023.74	1,029,403.93
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	749,471.37	841,482.99
33	АВЛАГА	132,331.26	53,264.42
35	БАРАА МАТЕРИАЛ	89,449.12	88,714.52
36	НӨӨЦИЙН БАРАА	58,772.0	45,942
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,197,324.44	2,343,962.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,197,324.44	2,343,962.96
39200	Биет хөрөнгө	1,961,688.77	2,108,797.29
39300	Биет бус хөрөнгө	235,635.67	235,165.67
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,227,348.67	3,373,366.89
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,242.65	41,283.35
41	БОГИНО ХУГАЦААТ ӨТ ТӨЛБӨР	20,242.65	41,283.35
41300	Өглөг	20,242.65	41,283.35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,207,105.53	3,332,083.54
51	Засгийн газрын хувь оролцоо	3,207,105.53	3,332,083.54
51100	Засгийн газрын оруулсан капитал	446,645.87	446,645.87
51200	Хуримтлагдсан үр дүн	2,651,985.48	2,776,963.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	108,474.18	108,474.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,227,348.18	3,373,366.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,061,703.34	2,141,806.11
11	ТАТВАРЫН ОРЛОГО	473,593.82	649,731.26
110	Орлогын албан татвар	445,376.99	431,446.74
1100	Хувь хүний орлогын албан татвар	443,036.99	461,589.67
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(30,451.82)
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	2,340.00	308.88
113	Хөрөнгийн албан татвар	16,953.43	20,156.63
118	Бусад татвар, төлбөр, хураамж	11,263.41	198,127.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	426,121.51	1,492,074.85
120	Тусламжийн орлого	-	1,104,214.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,161,988.01	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,711,520.47	1,970,002.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,711,520.47	1,866,864.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,652,686.47	1,816,208.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	682,817.76	814,896.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,512.14	92,639.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	223,598.22	277,484.84
2104	Хангамж, бараа материалын зардал	88,832.87	89,195.52
2105	Нормативт зардал	-	264
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,678.33	27,486.4
2107	Томилот, зочны зардал	28,850.00	29,730

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,495.44	112,218.47
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	373,901.71	372,293.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,834.00	50,656.06
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	103,137.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	350,182.87	171,803.73
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	141,523.17	73,625.71
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(141,523.17)	(73,625.71)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	208,659.70	98,178.01

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,931,525.39	2,222,953.21
11	ТАТВАРЫН ОРЛОГО	473,593.82	649,731.26
110	Орлогын албан татвар	445,376.99	431,446.74
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(30,451.82)
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	2,340.00	308.88
113	Хөрөнгийн албан татвар	16,953.43	20,156.63
118	Бусад татвар, төлбөр, хураамж	11,263.41	198,127.89
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,185.78	5,008.79
1181	Газрын төлбөр	753.20	35,241.82
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	5,324.42	157,877.29
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	295,943.56	1,573,221.95
120	Нийтлэг татварын бус орлого	295,943.56	311,505.25
122	Тусламжийн орлого	-	1,104,214.9
123	Улсын төсөвт орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	157,501.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,161,988.01	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,514,255.06	1,649,419.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,514,255.06	1,649,419.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,455,421.06	1,598,763.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	681,594.27	813,260.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,134.98	105,076.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	223,598.22	277,484.84
2104	Хангамж, бараа материалын зардал	81,731.82	69,450.37
2105	Нормативт зардал	-	10,264
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,678.33	52,996.4
2107	Томилолт, зочны зардал	28,703.00	29,877
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	147,989.34	84,794.06
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	146,991.10	155,559.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,834.00	50,656.06
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	417,270.33	573,533.83
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	147,165.00	481,522.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	147,165.00	481,522.2
2200	Дотоод эх үүсвэрээр	147,165.00	481,522.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(147,165.00)	(481,522.2)

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	270,105.33	92,011.63
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	479,366.04	749,471.37
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	749,471.37	841,482.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,998,445.83	2,998,445.83
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,998,445.83	2,998,445.83
9	Тайлант үеийн үр дүн	208,659.7	208,659.7
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,207,105.53	3,207,105.53
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,207,105.53	3,207,105.53
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	26,800	26,800
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,233,905.53	3,233,905.53
19	Тайлант үеийн үр дүн	98,178.01	98,178.01
20	2025 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл	3,332,083.54	3,332,083.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	870,711.60	961,236.51	(90,524.91)	110.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	479,705.10	649,731.26	(170,026.16)	135.44
110	Орлогын албан татвар	330,502.00	431,446.74	(100,944.74)	130.54
1100	Хувь хүний орлогын албан татвар	362,870.00	461,589.67	(98,719.67)	127.21
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(32,500.00)	(30,451.82)	(2,048.18)	93.70
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	132.00	308.88	(176.88)	234.00
113	Хөрөнгийн албан татвар	7,905.00	20,156.63	(12,251.63)	254.99
118	Бусад татвар, төлбөр, хураамж	141,298.10	198,127.89	(56,829.79)	140.22
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,960.00	5,008.79	(1,048.79)	126.48
1181	Газрын төлбөр	1,352.40	35,241.82	(33,889.42)	2,605.87
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	135,985.70	157,877.29	(21,891.59)	116.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	391,006.50	311,505.25	79,501.25	79.67
120	Нийтлэг татварын бус орлого	391,006.50	311,505.25	79,501.25	79.67
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,631,122.70	2,032,735.28	598,387.42	77.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,994,232.50	1,691,499.09	302,733.41	84.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,921,267.30	1,640,843.03	280,424.27	85.40

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	842,388.00	813,260.57	29,127.43	96.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,298.60	105,076.60	222.00	99.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	350,427.70	277,484.84	72,942.86	79.18
2104	Хангамж, бараа материалын зардал	87,342.00	68,866.83	18,475.17	78.85
2105	Нормативт зардал	12,000.00	10,264.00	1,736.00	85.53
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	62,000.00	60,064.30	1,935.70	96.88
2107	Томилолт, зочны зардал	34,522.00	29,877.00	4,645.00	86.54
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	212,298.40	83,093.10	129,205.30	39.14
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	214,990.60	192,855.79	22,134.81	89.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,965.20	50,656.06	22,309.14	69.42
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	10,500.00	-	10,500.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,465.20	50,656.06	11,809.14	81.09
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	369,883.70	341,236.19	28,647.51	92.25
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	267,006.50	-	267,006.50	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	749,471.37	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	841,482.99	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	29.00	29.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	98,206.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	98,206.30
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	98,206.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,584.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,584.50
2104	Хангамж, бараа материалын зардал	583.54
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,700.96
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	74,621.80
23	Дотоод эх үүсвэрээр	74,621.80

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй тул санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Залруулаагүй нийт **26,398.1** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч ХХС болон орлоготой холбоотой зөрчлийг арилгах 26,398.1 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн 26,398.1 мянган төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлснээс гадна санхүүгийн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын зөрчлийн нөлөөллийг үнэлж нийт 68,226.2 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг гэж үнэлснээр нийт **94,624.3** мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг зөрчил гэж үзлээ. Энэ нь аудитын төлөвлөлтийн үе шатанд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **29,600.1** мянган төгрөгөөс их байгаа боловч өргөн тархаагүй тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1. Сумын 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр биелсэн боловч үйл ажиллагааны орлого 757.7 мянган төгрөгөөр, бууны албан татвар 1,950.0 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 80.0 мянган төгрөгөөр, газрын орлого 410.6 төгрөгөөр, байгалийн ургамал ашигласны төлбөр 2,850.8 мянган төгрөгөөр нийт 5 нэр төрлийн орлого 6,049.1 мянган төгрөгөөр тасарсан, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, төсөвт бүрэн төвлөрүүлэх арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах, орлогыг сар улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлэх

3.1.2. Хоршоо хөгжүүлэх сангийн 4 зээлдэгчтэй холбоотой 20,349.0 мянган төгрөгийн чанаргүй хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна.” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг барагдуулах талаар холбогдох хууль, тогтоомжид заасан арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэн санг хохиролгүй болгох албан шаардлага хүргүүлэх

3.1.3. ОНХС-ийн Удирдлага мэдээллийн системд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 60,000 мянган төгрөгийн 3 арга хэмжээг мэдээлээгүй, зарим арга хэмжээний гүйцэтгэлийг дутуу оруулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2.1-т “Сум, дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг УМС-д байршуулаагүй зөрчлийг арилгаж, мэдээллийг нөхөж байршуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орлоготой холбоотой	1	6,049.1	-	-	1	6,049.1	-	-	-	-	-	-
ХХС-тай холбоотой	1	20,349.0	-	-	1	20,349.0	-	-	-	-	-	-
ОНХС-тай холбоотой	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
НИЙТ ДҮН	3	26,398.1	-	-	3	26,398.1	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	28,600.0	1	26,800.0	-	-	1	26,800.0	-	-	-	-
НИЙТ ДҮН	1	28,600.0	1	26,800.0	-	-	1	26,800.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗДТГ	9	157,501.5	1	1,000.0	8	156,501.5			-	-	-	-
ИТХ	7	22,593.4	1	1,125.0	6	21,468.4			-	-	-	-
ХХС	1	7,398.6	-	-	1	7,398.6			-	-	-	-
ЭМТ	1	1,974.5	1	1,974.5								
НИЙТ ДҮН	18	189,468.0	3	4,099.5	15	185,368.5			-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-